

АЯН ЗАМЫН  
ТЭМДЭГЛЭЛ

**ӨВӨР МОНГОЛД  
АЙЛЧИЛСАН НЬ  
(Бээжин, Хөх хотоор ороход)**

1990 он гарах ойртож байлаа. Хуучин оны 11-р сарын дундуур билээ. ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн төлөөлөгчид бид БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны их сургуулийн дэргэдэх БНМАУ-ыг судлах хүрээлэнгийн урилгаар өмнөх хөрш Хятад оронд албан ёсоор айлчилж, Хөх хот, Бээжингээр явж холбогдох эрдэм шинжилгээний хүрээлэн байгууллагууд, аж ахуй, соёлын газруудаар орж, эрдэмтэд болон албаны хүмүүстэй нүүр учирч, сонирхсон асуудлаар санал бодлоо солилцож ирлээ.

Манай төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд надаас гадна ДДСХ-ийн тасгийн эрхлэгч Дүнгэр-Яйчил орсон бөгөөд хуучин нутгаараа дахин явж үзэхэд улам ч таатай байсан биз.

Богд хаант Монгол улсын түүхийг судалдаг миний хувьд Өвөр Монголоор явж үзэх нь шинжилгээ судалгааны ач холбогдолтой явдал байлаа. Учир нь Өвөр Монгол бол миний судалгааны нэг чухал сэдэв, харин өнөөдрийн нийт хятад орон, түүний социалист байгуулалт ялангуяа гадаад бодлогыг Ази, Номхон далайн бүс нутгийн олон улсын байдалтай холбон авч үзэх нь бидний судалгааны өөр нэг зүйл юмаа.

Тэгээд бид тэр нэг өлзийт өдөр Улаанбаатараас галт тэргээр гарч, монгол-хятадын хил хүртэл монголынхоо өргөн талыг гатлан, өмнөдийг барин явсаар, Эрлянь буюу Эрээн хотноо хүрч, сая Өвөр Монголын нутгийн захад оров.

Хятадын нутагт орж очиход над нэгэн зүйлийн бодол аргагүй төрж, улс төрийн салхи шуурганаас болж, Монгол, Хятад хоёр нэн тултал хэлхээ холбоо тасарсан нь харамсалтай үйл явдал болон сэтгэлд бууж ирэх юм. Юу гэвэл, миний бие БНХАУ-ын нэг жилийн ойгоор Бүх дэлхийн ардчилсан залуучуудын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцож, Бээжингээс Мүгдэн, Шанхай, Кантон хүртэл явж, 1950 оны 10-р сарын 1-нд Тяньаньмэний талбайн индэр дээрээс хөдөлмөрчдийн их жагсаалыг харж байсан тэр мөч сэтгэл зүрхнээ илхэн буух ажээ.

Тэр цагаас хойш, хугацаа ч их өнгөрч, манай хоёр орны харилцаа түүхэн тодорхой шалтгаанаар сайдах муудахын нүүр үзэж, «соёлын хувьсгал»-ын шуурганд өртөж, хэт хуучирсан хэт хувьсгалч хоёр туйлын үзлийн тушаанд боогдож хохирч байсан удаатай.

Харин өнөөдөр өөрчлөн байгуулалт ил тод байдал, ардчилал социалист орнуудаар үл барам, бүх дэлхийгээр түгэж, БНМАУ, БНХАУ-ын харилцаа сэргэж хэвийн болж, хоёр орны ард иргэд албан, албан бусаар харилцан айлчлах болсон нь сайн хэрэг хэмээн тэмдэглээд өгүүлэхэд манай улсыг судалдаг хүрээлэнгээс биднийг угтахаар Эрлянд ирсэн хүндэт нөхөр Насантай учирч, тэнд түр зуур саатаж хилийн энэ нэг жижиг хотхоны ресторанд дайлуулахаар орвол зоогийн том гэгч өргөөний ханан дээр Чингисийн 8 хөлөг онгон талдаа нэн сүрлэг давхилдаж байгааг амьд мэт их л уран зурсан нь нүднээ тусч сэтгэлийг баясгана.

Хил дээрх хотхон гэхэд, Эрляний дэлгүүр хоршоонд бараа таваар, хүнсний бүтээгдэхүүн элбэг дэлбэг, ресторан гуанзанд дэлхийд алдартай хятад хоолоор хөнгөн шаламгай үйлчилж билээ.

Эрээн хотоос гараад Хөх хотын зүг хөдлөн Шилийн гол, Улаанцав аймгийн нутгаар явахад манай монголын өмнөх аймгууд адил нэлийсэн тал, элсэн манхан үргэлжилж, галт тэргэн дотор замын гудас монголоороо ч, хятадаар ч адил сайхан ярьдаг монгол охид хөвгүүд мэр сэр үзэгдэж, бид тэдэнтэй үг солих таатай байлаа.

Хөх хотноо хүрч очиход галт тэрэгний том гэгч буудал дээр бидний төлөөлөгчдийг БНМАУ-ыг судлах хүрээлэнгийн захирал Буян-Арвин гуай, орлогч захирал бөгөөд манай Монголд нэг жил дадлага хийгээд буцсан Баатар нар хэсэг ажилтныхаа хамт угтаж, Их сургуулийнхаа зочид буудалд буулгаж, анхаарал халамж тавин их л хүндлэн зочиллоо.

Биднийг маргааш нь Өвөр Монголын их сургуулийн захирал профессор Фан Тяньжи, орлогч захирал Баошан, гадаад хэлтсийн дарга Баатар нар дотноор хүлээн авч, амгаланг айлтгаж, дотно ярилцлаа. Профессор Фан хэлэхдээ та нар манай сургууль, хүрээлэнд Монголоос анх удаа ирсэн хүндэт зочид байна, хойшид хоёр талын харилцааг өргөжүүлж, шинжилгээ судалгааны талбарт хамтран ажиллаж, эрдэмтэд, мэргэжилтэн солилцож байх нь манай хоёр ард түмний найрамдал, хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулах юм гэв. Бид хариуд нь энэ айлчлал манай хоёр талын хамтын ажиллагааг улам өрнүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж итгэж байгаагаа илэрхийлэв.

Өвөр Монголын их сургууль 1957 онд байгуулагдсан нь Хятадын үндэсний цөөнхийн районуудаас анхных нь болжээ. Одоо 12 факультеттэй, 23 мэргэжлээр бэлтгэдэг, 2000 оюутантай, түүний дотор хан, манж, монгол, солонгос, хуй зэрэг үндэстэн ястантай, 200 аспирант докторанттай энэ их сургууль нийт Хятадын хэмжээгээр ч шинжлэх ухааны томоохон төв болжээ. Хөх хотын Их сургууль бүх барилга байгууламжийнхаа хамт хотын доторхи хот мэт ажээ. Энд оюутны дотуур байр, хичээлийн байр, багш нарын орон сууц, номын сан, биеийн тамирын талбай, байшин, хиймэл нуур зэрэг цөм нэг дор бөөгнөрчээ.

Их сургууль хотхон мэт байгуулагддаг нь Америк, Англи, Хятад, Японд их дэлгэрсэн уламжлал ажээ.

Хөх хотноо долоо хоног өнгөрүүлэх завсраа биднийг БНМАУ-ыг судлах хүрээлэнгийн хамт олон хэзээ ч мартагдашгүй найрсгаар хүлээн авч, ажил байдалтайгаа танилцуулсан билээ. Захирал Буян-Арвин болон бусад нөхөдтэй ярилцахад 20 шахам эрдэм шинжилгээний ажилтантай энэ авсаархан хүрээлэн манай БНМАУ-ыг тал бүрээс нь тун сайн судалж, сонин хэвлэлд нийтлэн, ном зохиол туурвиж Ар, Өвөр Монголын монгол ах дүү, хятад, монголын ард түмнийг харилцан ойлголцох, хоёр талд социалист нийгэм байгуулж буй ололт амжилт туршлагаа харилцан солилцох, өөр хооронд харилцан айлчлах, эдийн засаг, соёлын хэлхээ холбоо тогтоох, цаашилбал, БНХАУ, БНМАУ-ын найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх үйл хэрэгт багагүй хувь нэмэр оруулдаг юм байна гэсэн сэтгэгдэл төрлөө. Өвөр Монголын энэ хүрээлэн, манай ДДСХ хоёрын хамтын ажиллагааг улам зузаатгахын чухлыг цохон тэмдэглэцгээлээ. Энэ хүрээлэн өнөөдрийн Монгол орон хэмээх сэтгүүл хэвлүүлж байна. Тэр хүрээлэнгийн хамт олон бүгд ихэд чармайн ажиллаж, багагүй бүтээл туурвиж байх юм. Өвөр Монголын хадны бичээсийг нарийвчлан судалдаг бөгөөд манайхаас ижил төрлийн эрдэмтэдтэй холбоо тогтоох хүсэлтэйгээ Б. Болд илэрхийлснийг бид манай нөхдөд дамжууллаа. Монгол хэлний аялгууг судалдаг Түмэнцэцэг, манай улсын эдийн засгийн зарим асуудал судалдаг Наран нарын зэрэг шинэ танилтай боллоо.

Бид монгол хэл бичгийн профессор Чингэлтэй, Чойжинжав, монголын түүхийн профессор Ринчин зэрэг нэрт эрдэмтэдтэй уулзаж ярилцахад хичнээн их таатай байсныг хэлэхийн хамт, монгол судлалыг хөгжүүлэхэд эдгээр нөхдийн оруулсан гавьяа асар их болохыг зориуд тэмдэглэмээр байна. Гагцхүү манай болон Өвөр Монголын эрдэмтдийн одоо эхлэлтийн байдалтай байгаа хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, Монголын түүх, монгол-хятадын түүхэн ба одоогийн харилцааны зарим чухал асуудлаар хамтын бүтээл туурвиж байх цаг болсон болов уу гэж санагдах юм.

Дээрх эрдэмтэд монгол хэл бичиг, түүхээр хятад сурвалж бичгүүдийг өргөнөөр ашиглаж, гүн гүнзгий судалгаа хийж байна.

Өвөр Монголын түүхчид, хэл бичгийн мэргэжилтэн профессор нартай манай эрдэмтэд ямар нэг асуудлаар санаа бодол зөрөх явдал гарч болох боловч, шинжлэх ухааны үндсэн дээр хамтран ажиллаж, хамтын бүтээл туурвихад саад болох ёсонгүй гэж итгэж байна. Харин ч, үүний эсрэг, санал зөрөөтэй байж гэмээж нь маргаан сонирхолтой болдог ёсон бий билээ.

Бид бас Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгээр орж, захирал Зүшин нартай уулзаж ярилцлаа. Тус хүрээлэн «Нийгмийн шинжлэх ухаан» хэмээх сэтгүүлийг жилд 6 удаа нийтэлж, түүх, онол, практикийн янз бүрийн сэдвээр сонирхолтой баримт материал, шинжилгээ судалгаа хийж байна. Энд Гэсэр, Жангарын туульсыг судлах эмхэтгэх, Монгол үндэстний түүх бичлэгийн асуудалд их анхаарал тавьж байна. Монгол судлалын талаар баримт бичиг, судалгаа шинжилгээ, орчуулга зэргийг «Монгол тулгар бичгийн цуврал» хэмээх нийтлэг нэрийн дор «Монгол тулгар бичиг», «Монгол аман зохиол», «Монгол орчуулга» гэж гурван ангид хуваан хэвлэн нийтэлж байна. Тус хүрээлэнгийн захиргаа бидэнд бэлэг болгож «Тахил Зул хааны үлдэл Тансаг Бумба хааны ач Үйзэн Алдар хааны хөвгүүн үеийн өнчин Жангарын туульс»-ын тус бүр 1000 шахам хуудсыг 1, 2-р ботийг бусад номын хамт барилаа. Бусад ботиудыг нь үргэлжлэн хэвлэгдэх юм гэнэ.

Хөх хотыг Хятадын бусад хотуудын адил дугуйчдын хот гэмээр. Үнэхээр дугуй бол машин адил агаар бохирдуулахгүй, тэр ч байтугай, бие махбоди сайжруулдаг, ачаа хүн тээх хамгийн үр ашигтай унаа болохыг манай Монголд сайн мэддэг атлаа хотдоо дэлгэрүүлдэггүй нь гайхмаар. Ойрноос Улаанбаатараа чухамхүү дугуйчдын хот болгох эх оронч хөдөлгөөн өрнүүлбэл ямар вэ? Ийм хөдөлгөөнийг санаачлагчид байхгүй гэж үү? Суудлын машинд залардаг ихэмсэг зан арилаагүй юу? Эсгүл, дугуйтай хүнийг дор үздэг тал байна уу? Эсгүл, дугуй нь олдохгүй байна уу?

Өвөр Монголд байх хугацаандаа бид Хятадад өрнөж буй дөрвөн шинэчлэлийн үр дүнг нүдээр үзэж явсныг тэмдэглүүштэй.

Хөх хотод байхдаа олон сайхан барилга байгууламж үзсэнээс заримыг дурьдвал юуны өмнө Өвөр Монголын «Тиан» хэмээх телевизорын үйлдвэр багтана. Японы тусламжтай байгуулсан энэ үйлдвэрт одоо жилд 150000 өнгөт телевизор, 200000 харцагаан телевизор хийж, бүтээгдэхүүний загвар чанарыг ямагт өөрчлөн сайжруулж, зарим загварын телевизорыг Японд ч эргүүлэн борлуулдаг байна. Хамгийн сүүлчийн хийц загварыг «Хун» гэж нэрлэжээ.

Бид энэхүү телевизорын асар том үйлдвэрийг эхний ажиллагаанаас аваад эд ангийг угсрах, бэлэн болсон бүтээгдэхүүнийг шалгах, эцэст хайрцаглан баглаж тушаах хүртэл технологийн бүх дамжлагыг үзэж сонирхов. Нэгэнт бэлэн болсон телевизорыг Япон маркийн нарийн битүү лабораторид хийж бүхэлд нь тооцоолдог, үүнд чийг нойтныг

даах хэмжээ тогтоодог, эцэст нь хэврэг эсэхийг шалгадаг зэрэг олон төрлийн нарийн түвэгтэй ажиллагаа шаардагддаг ажээ.

Хөх хотноо Өвөр Монголын музейд очиж, Өвөр Монголын үндэсний дурсгалт үзмэрийг сонирхлоо. Музейн ажилтан Жигжидсүрэн, Насанбуян нарт музейгээ тайлбарлаж, «Монголын үндэстний дурсгалт зүйл» гэсэн сайхан альбом бэлэглэсэнд талархснаа энд үлдээж, өгүүлэхэд музейд ороход өмнөх ханан дээр Улаанхүүгийн «Үндэстнийхээ шилдэг соёлын уламжлалыг залгамжлан бадруулсугай» гэсэн үгийг монгол, хятадаар том үсгээр хадсан байна.

Энэ томоохон музейн өрөө тасалгаануудаар монгол үндэстний түүхийг эрт дээр үеэс эдүгээ хүртэл улируулан илтгэсэн бичиг баримт хөшөө дурсгал, гэр, сав суулга зэрэг аж ахуйн хэрэглэгдэхүүн, зан заншлын үзмэрүүдийг тавьсан нь бахдал төрүүлэм сайхан ажээ.

Өвөр Монголд үндэснийхээ зан заншлыг хэвээр хадгалах эрмэлзлэлийг энэ музейгээс гадна өөр бусад жишээн дээрээс мэдэж болно.

Нэгэн хүнийг тахин шүтэх явдал газар авч, хоосон бясалгал, догматизм, үндэсний дээрэнгүй, жанжирхах үзэл дэлгэрч байснаас болж социализм ихэд гажиж завхарсныг өөрчлөн байгуулалтын өнөө үед засч залруулж байна. Гажиж завхарсан социализмын их гай бол үндэстэн ястныг дээр дор үзэх, соёл, зан заншлыг нь устгах, бага ястныг ихэд нь, цөөнийг олохид уусгах, аль хүчтэй нь хүчгүйдээ эдийн засаг, улс төрийн элдэв дарамт шахалтыг үзүүлж цөлмөх, хохироох явдал байв. Ийм байсныг бид өнөөдөр ЗХУ-д болж буй өөрчлөн байгуулалтын явцаас үзэж байна. Ийм байсныг өнөөдөр Дорнод Европын социалист орнуудад өрнөж байгаа үйл явдлаас үзэж байна. Ийм байсныг манай Монголын байдал харуулж байна.

Өнөөдөр Хятадад үндэсний асуудалд нэлээд анхаарал тавьж байгаа нь илт байна. Үндэсний цөөнхийн хэлийг заах, соёлыг өрнүүлэх, эдийн засаг, засаг захиргааны эрх дархыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч байна. Ийм байдал Хөх хотод ч нэгэн адил байгааг бид үзлээ. Энд монгол хэл заах, монгол соёлыг хадгалан арвижуулахыг эрмэлзэж, ялангуяа монгол хэлээр ном зохиол хэвлэх явдал ихээхэн өндөр хэмжээнд хүрчээ. Бид Хөх хотноо монгол үндэстний сургуулиар ороход захирал Тянь Ванчин угтан авч, сургуулийнхаа байдалтай танилцууллаа. 1948 онд байгуулагдсан энэ сургууль 780 монгол сурагчидтай, 217 багцтай, хөдөө аймгуудаас ирсэн нь дотуур байранд байдаг. 3-р ангиас хятад, 1983 оноос 6-р ангиас япон хэлний хичээл ордог. Ноднин жил хоёр багш нь хэсэг сурагчдаа авч Японд жуулчлалаар явж, хэлний дасгал хийлгэж, Наран улсын амьдралтай танилцаж ирсэн гэнэ.

Дэлхийд техник, технологиор тэргүүний хөгжилтэй Японы дунд сургуультай манай улсын зарим дунд сургуулиуд хэлхээ холбоо тогтоон, Япон хэл заалгадаг болох асуудлыг бодож үзүүштэй мэт санагдана.

Энд өгүүлж буй сургуулийн бас нэг онцлог нь сургуульдаа хичээллэж байх үеэр хятадаар ярихыг хориглодог байна. Энэ бол монгол хэлээр тэнхимд байх үедээ яриулж байх гэсэн хэрэг, гэхдээ сургуулиас гараад явахад гудамж зээлээр аргагүй хятадаар ярих болдог нь мэдээж хэрэг. Үүнийг хүний олон цөөнөөр тайлбарлахаас өөр аргагүй. Тэр ч байтугай өвөрмонголчууд гэр орондоо ч хятадаар ярилцах нь олонтаа ажээ.

Ийм үзэгдэл ЗХУ-ын Буриадад ч нэгэн адил бий. Энд орос хэл давамгайлж, монгол хэл өөрөөр хэлбэл, монгол хэлний буриад аялгууг халж байна. Харин Сталин, буриадын эрдэмтэн С. Санжеев нар

буриад аялгууг монгол хэл бус, харин ч биеэ даасан тусгаар хэл мөн тухай онол дэвшүүлсэн нь шинжлэх ухааны ямар ч үндэсгүй зүйл бөгөөд их гүрний дээрэнгүй үзэлтэн бага үндэстний бялдууч үзэлтний хавсайдсан хэрэг болохоос хэтрэхгүй.

Ер нь социализм үнэхээр сайн нийгэм юм бол үндэстэн ястны хэл, соёлын тэгш эрхийг тунхаглаад зогсохгүй, тийнхүү тунхагласнаа амьдрал дээр хэрэгжүүлэхийг эрхэмлэх ёстой билээ. Улс төр, эдийн засгаар ч мөн адил тэгш эрхтэй баймаар ажээ.

Бид Хөх хотод байхдаа бас монгол үндэстний хүүхдийн цэцэрлэгээр орж танилцаж, сайхан сэтгэгдэл төрлөө. Цэцэрлэгийн эрхлэгч Сэцэнгуа гуай найр тавин ажил байдлаасаа ярьж, ангиудаар оруулж, бяцхан монгол хүүхдүүдтэй танилцуулж өгсөн билээ. Энэ хүүхдийн цэцэрлэг 1982 онд анх байгуулагдсан, 4—5 настайгаас хүүхдийг хүлээн авдаг, одоо багш нар 80, бүх хүүхэд 400 гаруй байна. Цэцэрлэгээ төгсөгчдийн 40 хувь нь монгол сургуульд 60 хувь нь хятад сургуульд орж суралцана.

Бид анги бүлгээр орж үзвэл Улаанцав, Шилэнгол зэрэг хөдөө аймгууд, Хөх хотын хүүхдүүд хүмүүжиж байна. Хөдөө аймгаас ирэх нь ховор гэж ярьж байв. Бид нэг бага ангид ороход Улаанцав аймгаас ирсэн хөөрхөн бяцхан охин «Би Монгол хүн» гэдэг манай зохиолч Ч. Чимидийн шүлгийг их л баяр баясгалантай, бахдалтай уншиж байхыг сонсож, өөрийн эрхгүй сэтгэл уярах юм. Зарим хүүхэд хятад нэртэй боловч монгол ястан байна. Бидэнтэй танилцсаны дотор Чилгэр, Нандан, Гонгор, Адис, Урнаа, Е жүн зэрэг бяцхан охид хөвгүүд байлаа.

Нэг зүйлийг цохон тэмдэглэхэд Өвөр Монголын ирээдүй болсон эдгээр бяцхан хүүхдүүд цэцэрлэгт байхаасаа эхлэн уйгаржин монгол үсгээр, өнгөт зурагтай, маш сайхан хэвлэсэн цагаан толгойг үзэж, бичиг үсэгт суралцах анхныхаа алхам хийдэг нь их л бахархалтай санагдлаа.

Эдгээр гоёхон хувцасласан бяцхан монгол охид, хөвгүүд Ар Монголоос ирсэн зочид биднийг үзээд хэрхэн баярлаж, хэрхэн цагаан толгойн сурах бичгээ уран уншидгаа бидэнд үзүүлж, хэрхэн биднийг үдэж гаргаж байсан нь хэзээ ч мартагдашгүй сэтгэл төрүүлсэн. Тэгээд бас яагаад ч юм сэтгэлд нэг л уйтгар төрүүлэх юм.

Хөх хотноо бид монгол үндэсний эдлэлийн үйлдвэрээр очиж үзлээ. Энд ажилладаг хэсэг монгол, хятад ажилчид монгол эрмэг гутал, эмээл, гөлөм, гоёл чимэглэлийн зүйлс зэргийг их урнаар хийж байгааг үзэж сонирхсоны тэмдэглэл үлдээе.

Иньшан нурууны өмнө бэлд орших Хөх хот хөшөө дурсгал, үзэсгэлэн музей, сүм хийдээр элбэг хот байна.

Хотоос өмнө этгээдэд Ван Жаозюний гэрэлт хөшөө байдаг ажээ. Манай тооллын өмнөх 33 онд, он дарааллын бичгээс үзвэл, Хятадын Хань улсын эзэн хаан Хань Юаньди хүннүгийн эзэн Ху Хань-е-д өөрийн ордны дотроос нэгэн гуалиг бүсгүй Ван Жаезюнийг эхнэр болгон өгсөн ажээ.

Улс орнууд хоорондоо энэ мэтээрээ ураг төрлийн холбоо тогтоох явдал олон улсын харилцаанд эртнээс нааш уламжлагдан ирсэн заншил ажээ.

Бид Хөх хотод байхдаа тэндэхийн түүхт 7 хөшөө дурсгалын нэг болох Төв болсон шарил эрдэнэт суварга буюу Таван суварга үзэв. Чин улсын Тэнгэр тэтгэсэн хааны эхний онд цогцолсон энэ Суварга үнэхээр уран баримлын гайхамшигт дурсгал бөгөөд хананы гоёл чимэглэл, манж монгол үсэг сийлсэн нь маш нарийн ажээ.

Хөх хотын хуучин хэсэгт орших Ширээт сүмээр орж сонирхов. Хуучин Хөх хотын гудамж зээл, муруй тахир, нарийхан, манай хуучин Улаанбаатарын өргөн чөлөөрхүү хятад иргэдийн суудаг гудамж зээлтэй яг адил. Ширээт хутагтын энэ сүмд сахиул хоёр-гурван монгол лам нартай танилцаж, урьд цагт энд олон лам нар хурал хурж их л хөл үймээнтэй байдаг тухай сонсоход тэр үе сэтгэлд төсөөлөгдөх ажээ. Ширээт сүм Мин улсын эзэн хаад Лун-цин, Вань-ли-гийн үед байгуулагджээ. Сүмийн доторхи хурал номын тахил тавилга, луу тэргүүтнийг дүрсэлсэн гоёмсог сайхан багана туурга, Сахъямуни бурхны дүр, гадна орой дээрх цутгамал алтан лууг ихэд сонирхон үзэв.

Хөх хотноо телевизийн төвийг сонирхов. Тэндэхийн орлогч дарга Н. Элбэрэлт Хөх хотын теле нэвтрүүлгийн тухай дэлгэрэнгүй танилцуулж өглөө. Их даруу, сайхан зантай хүн ажээ. Бидэнд өөрийн бичсэн «Сонин мэдээний ухааны тухай товч өгүүлэх» хэмээх номоо дурсгав. Энэ ном нь 1989 онд Бээжинд 2 дахь удаагаа хэвлэгджээ.

Хөх хотын телевизийн төв нь асар том барилга байшинтай, япон, АНУ-ын болон Хятадын өөрийн нь теле нэвтрүүлгийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Хөх хотод байхдаа бидэнд эндэхийн теле нэвтрүүлэг нь агуулга хэлбэр сайн, үйл явдлын мэдээллийг цаг алдалгүй нэвтрүүлдэг, хөнгөн шуурхай байдаг юм байна гэсэн сэтгэл төрж билээ.

Өвөр Монголд очсон зочин гийчид Чингис хааны онгон ордныг үзэхгүй буцах нь ховор. Бид ч, монгол хүмүүс болохоор юуны өмнө Чингис хааны онгонд очиж үзэхийг хүсэхэд Их сургуулийн гадаад хэлтсийн дарга Баатар (бид гадаад яамны сайд гэдэг байлаа) аль хэдийнээ товлочихсон байсанд ихэд баярласан билээ.

Тэгээд бид нэгэн мартагдашгүй өглөө Хөх хотоос өмнө өгүүлсэн Баатар, бас Буян-Арвин гуайн хүрээлэнгийн ажилтан Нараны хамт «Волга» машинаар Чингис хааны онгон орохоор мордсон билээ.

Хөх хотын хойгуур баруунаа олон километр үргэлжилсэн Иньшан уулын бэлээр нарийн засмал замаар манай машин хурдална. Хятад орон хүн олонтой тул энэ зэлүүд газар ч хүний бараа тасарна гэж байхгүй. Өмнөөс нүүрс ачсан янз бүрийн маркийн машин, бас жижиг тракторууд утаа савсуулан жирэлзэн өнгөрөх ажээ. Бид явсаар Улаанцав аймгийн баруун талаар өнгөрч. Баяннуур аймгийн өмнөдөд орших тусгай аж үйлдвэрийн районы төв Бугат хотноо хүрэлцэн очиход энэ бол Хойд Хятадын үнэхээрийн том үйлдвэрийн газар ажээ. Нүд алдам ээрэм талд байгуулагдсан энэ Бугат хотын аж үйлдвэрийн олон өндөр яндан огторгуйг багандан, хар утаа суунаглуулан байх нь сүртэйг хэлэх юун. Хавь газар харанхуйлагдан утаа манан хөвөрнө.

Бид Бугат хотноо саатсангүй, дундуур нь зүсэн гарч, үйлдвэрийн бас нэг төв хот Дүншэнд очиж буудаллан, дэнлүү зүүсэн нэгэн хятад гуанзанд орж, хоол зооглож, бага зэрэг замын алжаал тайлж амсхийв. Энд үйлчлэгчид нь монгол охид байх бөгөөд хятад, монгол хэлээр ярих юм. Ар Монголоос ирсэн зочид гэхэд их л сонирхох бөгөөд энэ тэрийг ярьсаар бага саатаад цаашаа мордов.

Дүншэн хотоос хэсэг давхитал домогт Хатан гол Шар мөрөн алсаас мэлтэлзэнхэн харагдах нь сэтгэл хөдлөм ажээ. Хатан гол булингартанхан намуухан урсах нь их үдийн нарны туяанд гялалзана.

Мөнгөлөг ус нь мэлтэлзсэн Хатан гол ард үлдэж, бид Их Зуу аймгийн нутагт орж ирэхэд, манай говийн аймгууд шиг элсэн манхан, довтолгод нүдний хараанд тусахаас өөргүй, өргөн сайхан тал замын хоёр талд үргэлжилнэ. Ой мод үзэгдэхгүй, гагцхүү харгана бутарга

зэрэг сөөг л дайралдаж, хааяа энд тэнд хятад шавар пүнзүүдээс утаа гарах нь харагдана.

Тэр өдрийн оройхон бид мөн аймгийн Ордос нутгийн өмнө бие дэх өвс ногоо халиурсан, мод ногоорсон, гол горхи мэлтэлзэн урссан, таван хошуу мал бэлчээрлэсэн тансаг сайхан Гандирын шилд буй Эзэн хорооноо, Чингис богдын онгонд хүрэлцэн очиход ордонг хариуцагч, Чингис хааны судлалын нийгэмлэгийн орлогч захирал бөгөөд ерөнхий нарийн бичгийн дарга, Чингис хааны судлалын хүрээлэнгийн орлогч захирал Шаралдай гуай халуун дотноор угтан авлаа.

1954 онд Хятадын Төрийн Зөвлөлийн шийдвэрээр байгуулсан энэ Чингисийн ордон гайхамшигтай сайхан барилга байгууламж агаад 5 түмэн 5 мянган дөрвөлжин метр талбайтай, гол ордон нь 24 метр өндөр, жигүүр хоёр ордон нь 18 метр өндөр. Ордны тус газраа олон жижиг гуулин хонх өлгөсөн нь салхины аясаар жингэнэж, Чингисийн үед байгаа юм шиг санаа төрүүлэх ажээ.

«Чингис хааны онгон» хэмээх лавлахад Чингисийн жинхэнэ шарил нь Онон, Хэрлэн, Туул гурван голын эхэнд Бурхан Галдун ууланд юм уу, Алтай ханы ард, Хэнтэй ханы өвөрт Их Өтөг хэмээх газраа бий тухай олон сурвалж бичгээс иш татаад, энд Гандирийн толгод дээр онгон барьсан учрыг бас л домгоор тайлбарлажээ. Чингис хаан Тангадыг дайлаар энэ газраар гарахдаа ташуураа унгасан боловч, авсангүй, явж хэлэлдээ «энэ газар өл буга бэлчээрлэлтэй, өвөөлжин шувуу өндөглөлтэй, эвдэрхий төрийг байгуулалтай, энэ бие жаргалтай их сайхан байна» гэж хэлсэн гэсэн домог бий. Бас өөр нэг домогт өгүүлэхдээ Чингис хаан Тангад газар хальсны дараа шарилыг нь хойш нутагт нь аваачиж явахад хасаг тэрэгний булуу нь энд шаварт шигдсэн тул нэг хэсэг хувцас хунарыг нь орхиж явсан гэдэг.

Чингис хааны онгоны ордон дотор юм бүхэн үнэхээрийн сүртэй, гайхамшигтай. Чингис хааны хийморийг бадраасан амьсгалтай. Одоо ХХ зуун биш, ХШ зуун байгаа юм шиг бодол төрүүлэхээр тавилга чимэглэл хийжээ. Энд их Чингис хаан суугаа цагаан гантиг чулуун хөшөө байна. Ордны дотор орсон зочид Чингис хаан ба Бүртгэлжин хатны цомцогийн өмнө хадаг барин сэржим өргөх ёстой аж. Бид заншлаа үйлдэл хийлээ. Ордны ханан дээр Чингис ба түүний баатруудын үйл ажиллагаа, байлдан дагуулал, тэр үеийн аж ахуйн байдлыг тод томруун зурж үзүүлжээ. Чингисийн хар сүлд туг, баатруудын нь эмээл зэрэг онц сонин үзмэрүүд байх юм.

Өгөөдэй хааны үеэс Чингис ба Бүртгэлжин хатны 8 цагаан гэрийг шүтээн болгон тахисаар одоо хүрсэн байна.

Шаралдай гуай бидэнд ярихдаа Чингис хааны онгон шүтээний их бага тайлгыг дархад бид 700 жилийн турш үйлдсээр одоо хүрлээ. Хэрвээ БНМАУ-д Чингис хааны шарилыг монгол-японы хамтарсан экспедици олдог юм бол би очиж, тайлга хийхийг үзүүлж болох юм гэж байлаа.

Анхнаас Чингис хааны онгоныг 500 дархад сахин хамгаалсаар ирсэн, одоо бид 300 дархад үлдээд байна гэж Шаралдай гуай ярилаа.

Бид Чингис хааны онгонд зочид дэргэдэх зочид буудалд бид нэг өнжөөд, эрхэм хүндэт Шаралдай гуайгаар дайлуулаад, маргааш нь Хөх хотын зүг жолоогоо эргүүллээ.

Бид Хөх хотоос Бээжин очиж тэнд 2-3 өнжиж, ижил төрлийн хүрээлэнгүүдээр орж шууд харилцаа тогтоох зорилготой байсан билээ.

Гэтэл галт тэрэгний билет олдохгүйн харгаагаар Бээжинд нэг л өдөр өнжөөд орой нь нутгийн зүг хөдөлсөн билээ.

Бээжинд бид байхдаа Хятадын нийгмийн ухааны академийн Японы судлалын хүрээлэнгийн захирал Луо Вейлонг, мөн ЗХУ ба Дорнод Европын орнуудыг судлах хүрээлэнгийн захирал профессор Лу Наньцюань нартай уулзаж, танилцаж, ажил төрлийн холбоо тогтоож хамтран ажиллах асуудлаар ярилцлаа.

Мөн бид Бээжинд байх үеэр бүх хятадын сэтгүүлчдийн холбооны нийгэмлэгийн хэвлэж эхэлж буй «Гүүр» хэмээх сэтгүүлийн орлогч эрхлэгч Жао Женлин, эмэгтэй сурвалжлагч Лю Юнью нартай уулзаж, хэрхэн энэ сэтгүүлийг монгол уншигчидтай болгох асуудлаар ярилцан тогтсон билээ.

Бид Хөх хотод байхдаа ч зөвхөн зочны төдий байсангүй, мэргэжлийн бус ч атугай, ажил хэргийн холбоо тогтоох талаар анхаарч явсныг тэмдэглэлтэй. Жишээ нь, Хятадын үндэсний нутгийн ба амьтны хоёрдогч бүтээгдэхүүн экспортлох импортлох пүүсийн Хөх хотын салбарын Тай Сизен, Ли Вей нартай уулзахад манай монголын малын өлөн гэдсийг дэлхийн зах зээлийн үнээс илүүгээр худалдан авч байх асуудал тавьсаныг манай зохих байгууллагад бид дамжуулсан билээ.

Хөх хотод байхад биднийг гүнээ хүндэтгэн хүлээн авсан Фан Тианжи, Бао Шан, Баатар, Ринчин, Чойжанжав, Лучингээс гадна, Буян-Арвин, Оюун, Рашидонров, Занабазар, Лхасүрэнгийн гэр бүл бас Насан, Наран, Түмэнцэцэг тэргүүлэн БНМАУ-ын судлалын хүрээлэнгийн хамт олонд гүнээ талархан манай өмнөд хөрш Өвөр Монголоос үнэнхүү сайхан сэтгэгдэлтэй буцсанаа ийнхүү тэмдэглэе.

**1989 оны 11-р сарын 7-23. Хөх хот-Бээжин-Улаанбаатар**

**Ш. САНДАГ, Д. ДҮНГЭР-ЯЙЧИЛ**

ДОРНОДАХИНЫ  
УРАН ЗОХИОЛ

ЯПОНЫ ХАЙКУ

Японы яруу найргийн уламжлалт төрөл зүйлийн нэг нь хайку хэмээх 5—7-5 үе буюу нийт 17 үеийн тогтолцоог дэг ёсыг баримтлан, үгийн яруу, утгын гүн, дууны айзам хэмнэлийг гайхамшигтай илэрхийлсэн богино шүлэг юм. Хайку нь японы түүхийн Мурамачи-гийн үе буюу XIV—XVI зуунд ихэд дэлгэрсэн эртний Рэнка (холбоо дуу гэсэн утгатай) хэмээх яруу найргийн нэгэн төрлөөс уламжлан үүсч Эдогийн үеийн эхэн буюу XVI зууны эхнээс яруу найргийн сонгодог нэгэн чиглэл болжээ. Рэнка-гийн эхний мөр нь 5—7—5 үеийн тогтолцоотой бөгөөд шүлгийн хэв маягийн хувьд хайкутай нийцэж байдаг ажээ.

Хайку нь дээр дурдсан 5-7-5 үеийн тогтолцооноос гадна өөрийн бүтэцдээ «киго» буюу цаг улирлыг тусгасан хэллэг, «кирэжи» буюу шүлгийн доторхи утгыг төгсгөх туслах үгийг заавал багтаасан байд таараа утга зохиолын бусад төрөл зүйлээс ялгарах онцлогтой. Орчин үед хайку, танка (богино дуу) хоёр нь японы цөөн мөрт яруу найргийн гол хоёр урсгал болон хөгжиж байна.